

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2015 он/

Төсвийн шууд захирагчийн гэрээнд тухайн нэгж хариуцахаар тусгагдсан арга хэмжээ (гарц буюу ажил, үйлчилгээ)	Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт(тоо, чанар, хугацаа)-ийн хүрэх түвшин				Төсөвт өртөг, эх үүсвэр /сая төг/	Хариуцах нэгжийн нэр
	Гүйцэтгэх ажил	Гүйцэтгэх хугацаа	Суурь түвшин	Зорилтот түвшин		
1	2	3	4	5	6	7
<b>НЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ</b>						
<b>"1.0. Салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>						
<b>ТИНСББ-4.1</b> 1.1. Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийн хүрээнд боловсруулсан, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцсэн "Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр" болон "Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр"-тэй байх бөгөөд дээрх хөтөлбөрүүдийг үндэсний хууль тогтоомж болон олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн тухай бүр шинэчилж байна.	<b>1.1.1. "Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр"-ийг батлуулан хэрэгжүүлнэ.</b> – ИНААХ-ийн завсрын дүн шинжилгээ хийх; – ИНААХ-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гаргах; – Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны бодлого, зорилгыг боловсруулан батлуулах; – Иргэний нисэхийн эрх зүйн орчныг тодорхойлох, холбогдох зохицуулалтыг хийх; – Аюулгүй ажиллагааны сайжруулалт, сургалт, сурталчилгаа, соёлыг нэвтрүүлнэ.	I-XII сард	Хөтөлбөрийг боловсруулан ЗТЯ-нд хүргүүлсэн.	Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр батлагдаж Иргэний нисэхийн эрх зүйн орчинд завсрын дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг тодорхойлох, Аюулгүй ажиллагааны хөтөлбөр, удирдлагын тогтолцооны сургалтад холбогдох ажилтнуудыг үе шаттай хамруулан нисэхийн аюулгүй ажиллагааг хангах талаарх мэдлэг дээшилсэн байна.		НААХЗГ НААХЗДХА
	<b>1.1.2. "Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулна.</b>	I-XII сард	Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулахаар санал боловсруулан ЗТЯ-нд хүргүүлсэн.	Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх, Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байгууллагуудыг мэдээллээр хангах, мөн хөтөлбөрт тусгах нэмэлт		НБУГ

				өөрчлөлтийн төслийг Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн гишүүн байгууллагуудад хүргүүлж санал авч, тусгана.		
<b>"2.0. Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>						
<b>ҮХЦБ-5.3.1.2</b> 2.1. Иргэний нисэхийн тухай хууль, стандарт, дүрэм журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулахын зэрэгцээ зарим хуулийг шинээр баталж мөрдүүлнэ	<b>2.1.1. ИНД-121 “Агаарын тээврийн үйл ажиллагаа-багтаамж ихтэй онгоц”, ИНД-101 “Хүнгүй нисдэг төхөөрөмж болон автожир-үйл ажиллагаа” (2) ИНД-91 “Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм” багц дүрмүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулж, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахаар Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</b>	I-XII сард	-	Аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт боловсронгуй болсон байна.		ХЭЗДБГ
	<b>2.1.2. ИНД-66 “Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл” дүрмийг шинэчлэн боловсруулж, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулахаар Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</b>	I-XII сард	-	Аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт боловсронгуй болсон байна.		ХЭЗДБГ
	<b>2.1.3. ИНД-145 “Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага-гэрчилгээжүүлэлт” дүрмийг шинэчлэн боловсруулж, Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулахаар Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.</b>	I-XII сард	-	Аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт боловсронгуй болсон байна.		ХЭЗДБГ
<b><u>ТИНСББХАХТ-2.1.2</u></b> 2.2. Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1993 оны 01 дүгээр сарын 30-ны 23 дугаар тушаалаар баталсан "Аэродром ашиглалтын	2.2.1. Барилгын норм ба дүрэм БНБД 3.06.05-89 “Аэродром”-г шинэчлэн MNS болгоно.	IV-XII сард	ИНЕГ-ын захиалгаар Барилгын хөгжлийн төвийн Норм нормативын сангийн төслөөр “Аэродром” БНБД-ийг	Аэродромын барилгын ажлын технологи, барилгын материалд тавигдах шаардлагууд нь олон улсын жишиг норм, дүрэмтэй нийцэх ба		НБУГ

дүрэм", 1997 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 47 дугаар тушаалаар баталсан "Аэродромын үйл ажиллагаа эрхлэх дүрэм", 1998 оны 159 дүгээр тушаалаар баталсан "Иргэний агаарын хөлгөөр тээвэр хийх дүрэм"-үүдийг шинэчлэн боловсруулж, батлуулна			боловсруулж дуусан, хянагдаж байгаа ба СХЗГ-ын техникийн хороогоор хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.	барилга, засварын ажлын чанар сайжирна.		
<b>"3.0. Иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>						
3.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын аудит шалгалтын дүгнэлтэд дурьдсан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж, Continuing Monitoring Approach-ын хөтөлбөрийн дагуу Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ыг мэдээллээр хангана.		I-XII сард	-	Олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг ахиулсан байна.		НААХЗГ ХЭЗДБГ
3.2. ИНД-61, 63, 65, 66, 67 дагуу иргэний нисэхийн мэргэжлийн ажилтнуудыг үнэмлэхжүүлнэ.	3.2.1. Иргэний нисэхийн мэргэжлийн ажилтнуудыг үнэмлэхжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.	I-XII сард	Судалгаа хийж, үнэмлэх зэрэглэл олгох ажилтнуудын тоог гаргасан.	Нисгэгч, нисгэгчээс бусад нисэх багийн гишүүдийн үнэмлэх сунгалт-80; Агаарын хөдөлгөөний үйлчилгээний ажилтан /нислэгийн удирдагч, нислэгийн мэдээллийн ажилтан/-110; Агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэхийн сунгалт-60; Эрүүл мэндийн гэрчилгээний сунгалт-гэрчилгээ олголт-120;		НААХЗГ
3.3.ИНД-141-ийн дагуу сургалтын байгууллагын эрхийг баталгаажуулах аудит хийнэ.	3.3.1.Гадаадын сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.	II-III улирал	-	Гадаадын 1 сургалтын байгууллагад аудит хийж, гэрчилгээг сунгасан байна.		НААХЗГ
3.4.Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгох, сунгахтай холбогдсон ажлуудыг хууль, дүрэм, журмын	3.4.1.Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэнэ.	II-IV улирал	-	3 агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг сунгасан байна.		НААХЗГ

хүрээнд хийж гүйцэтгэнэ.					
3.5. Иргэний нисэхийн агаарын хөлгийг Монгол Улсад бүртгэх, улсын бүртгэлээс хасах, агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрөх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.	3.5.1.ИНД-47-ийн дагуу агаарын хөлгийг Монгол Улсад бүртгэх, бүртгэлээс хасах, бүртгэлд өөрчлөлт оруулна.	I-XII сард	-	Агаарын хөлгийн бүртгэлд өөрчлөлт оруулсан байна.	НААХЗГ
	3.5.2.ИНД-21-ийн дагуу агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрөх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, тусгай нислэгийн зөвшөөрөл олгох, агаарын хөлгийн загварын өөрчлөлтийг баталгаажуулах, дуу чимээний гэрчилгээ олгох, экспортын нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.	I-XII сард	-	Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын 18 гэрчилгээг сунгасан байна. АТК-уудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрөх, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, тусгай нислэгийн зөвшөөрөл олгох, агаарын хөлгийн загварын өөрчлөлтийг баталгаажуулах, дуу чимээний гэрчилгээ, экспортын НТЧ-ын гэрчилгээ олгоно.	НААХЗГ
	3.5.3.ИНД-144-ийн дагуу агаарын хөлгийн шатахуун хангамжийн байгууллагын гэрчилгээг олгох, сунгана.	II-IV улирал	-	Шатахуун хангамжийн 3 байгууллагын гэрчилгээг сунгасан байна.	НААХЗГ
	3.5.4.ИНД-145-ын дагуу агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ олгох, сунгана.	II-IV улирал	-	Агаарын хөлгийн техник үйлчилгээний дотоодын 8, гадаадын байгууллагаас хүсэлт ирүүлсний дагуу гэрчилгээ олгоно.	НААХЗГ
3.6.Агаарын тээвэрлэгч, үйлчилгээ, хангамжийн байгууллагуудыг гэрчилгээжүүлнэ.	3.6.1.ИНД-139-ийн дагуу Аэродромын гэрчилгээ, түр зөвшөөрөл олгох, сунгана.	III-IV улирал	-	Орон нутгийн 20 нисэх буудлын гэрчилгээний хугацааг сунгана.	НААХЗГ
	3.6.2.ИНД-140-ийн дагуу Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг сунгах үзлэг шалгалт хийнэ.	III-IV улирал	-	Орон нутгийн 2 нисэх буудлын аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг сунгасан байна.	НААХЗГ
	3.6.3.ИНД-171-ийн дагуу Агаарын навигацийн техникийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг сунгах үзлэг шалгалт хийнэ.	IV улирал	-	ТХҮА-ны гэрчилгээг сунгасан байна.	НААХЗГ

	3.6.4.ИНД-172-ийн дагуу Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээний хугацааг сунгах үеийн үзлэг шалгалт хийнэ.	II улирал	-	АХҮА-ны гэрчилгээг сунгасан байна.		НААХЗГ
	3.6.5.ИНД-173-ын дагуу Нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын үндсэн гэрчилгээ олгох үзлэг шалгалтыг хийнэ.	II-III улирал	-	Шалгалтын нислэг, зураглалын албанд үндсэн гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалтыг гүйцэтгэсэн байна.		НААХЗГ
	3.6.6.ИНД-174-ийн дагуу УЦУОШГ-ын харъяа Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээг сунгана.	II улирал	-	НЦУТ-ийн гэрчилгээг сунгасан байна.		НААХЗГ
3.7.Иргэний нисэхийн байгууллагуудын үйл ажиллагааны заавар, журам, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавина.	3.7.1. ИНБД-ийн хүрээнд Иргэний нисэхийн гэрчилгээжсэн байгууллагуудын үйл ажиллагааны заавар, журмуудын өөрчлөлтийг хянах, баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавина.	I-XII сард	-	Гэрчилгээжсэн байгууллагуудын үйл ажиллагааны заавар, журамд өөрчлөлт орох бүрт хянаж баталгаажуулсан байна.		НААХЗГ
	3.7.2.Иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөр, онцгой байдлын үед ажиллах журмыг хянах, баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавина.	I-XII сард	-	ИНД-108, 109-ийн хүрээнд Агаарын тээврийн ба ачаа тээвэр зуучлалын байгууллагуудын Аюулгүй байдлын хөтөлбөр, Онцгой байдлын үед ажиллах журамд өөрчлөлт орох бүрт хянаж баталгаажуулсан байна.		НААХЗГ
3.9.Сорилт шинжилгээ, шалгалт тохируулга, баталгаажуулалтын ажил хийнэ.	3.9.1.Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын иж бүрэн шинжилгээ хийнэ.	I-XII сард	-	<b>300</b> дээжинд сорилт шинжилгээ хийнэ.		НААХЗГ
	3.9.2.Иргэний нисэхийн салбарт ашиглаж байгаа бүх төрлийн радио, цахилгааны болон цулын хэмжих хэрэгслүүдийн шалгалт тохируулга, баталгаажуулалтын ажлыг хийнэ.	I-XII сард	-	Радио цахилгааны хэмжих хэрэгсэл– <b>30</b> , цулын хэмжих хэрэгсэл– <b>20</b> ширхэгийг тус тус баталгаажуулна.		НААХЗГ
	3.9.3.Иргэний нисэхийн салбарт ашиглаж байгаа бүх тоног төхөөрөмж, барилга байгууламжийн газардуулга болон аянга зайлуулагчийн эсэргүүцлийн хэмжилтийн ажил хийнэ.	I-XII сард	-	Тоног төхөөрөмж, барилга байгууламжийн газардуулга болон аянга зайлуулагчийн <b>250</b> ширхэг хэмжилтийг хийнэ.		НААХЗГ

<b>"4.0. Эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар олон хэлбэрийн өрсөлдөх орчинг бий болгох, иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийг дэмжих" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>						
<b>ТИНСББ-2.2.4</b> 4.1. Агаарын харилцааны асуудлаар Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинээр байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах замаар олон улсын нислэгийн чиглэл, давтамжийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.	<b>4.1.1. Монгол Улсын Засгийн газар болон Малта Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийг шинээр байгуулна.</b>	IV улиралд	Малта Улсын талаас Агаарын харилцааны хэлэлцээр шинээр байгуулах талаар хүсэлт гаргасан.	Агаарын харилцааны хэлэлцээр байгуулсан байна.		АТЭЗЗГХАГ
	<b>4.1.2. Монгол Улсын Засгийн газар болон Камбож Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээрийг шинээр байгуулна.</b>	IV улиралд	Камбож Улсын талаас Агаарын харилцааны хэлэлцээр шинээр байгуулах талаар хүсэлт гаргасан.	Агаарын харилцааны хэлэлцээр байгуулсан байна.		АТЭЗЗГХАГ
	<b>4.1.3. Австрали Улстай гуравдагч талын оролцоотой аяллын дугаар хамтран эзэмших зохицуулалтыг тохирно.</b>	II улиралд	Австрали Улстай гуравдагч талын оролцоотой аяллын дугаар хамтран эзэмших зохицуулалтын төслөө ирүүлсэн.	Агаарын тээвэрлэлтийг зохицуулах эрх зүйн орчин сайжирсан байна.		АТЭЗЗГХАГ
	<b>4.1.4. Тайландын Вант Улстай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулна.</b>	II улиралд	Агаарын харилцааны хэлэлцээр байгуулсан боловч нисэн очих цэгээр зөвхөн Бангкок байдаг.	Агаарын харилцааны хэлэлцээрийн Маршрутын хуваарьт өөрчлөлт орсон байна.		АТЭЗЗГХАГ
<b>ТИНСББ-3.5</b> 4.2. Хөрш зэргэлдээ ОХУ болон БНХАУ-тай агаарын тээврийн хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол Улсыг энэ хоёр улсын хооронд агаарын тээврийн транзит үйлчилгээний төв болгох чиглэлийг баримтална.	4.2.1. "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын ирэгчийн танхимаас явагчийн танхимд нэвтрэх гарцыг транзит бүртгэлийн цэг, аюулгүй байдлын үзлэгийн цэгийн хамт гаргах барилга засварын, тоног төхөөрөмж суурилуулах болон заалын үйлчилгээний цагийн хуваарт өөрчлөлт оруулах ажлуудыг гүйцэтгэнэ.	I-IV сард	Монгол Улсын үндсэн нисэх буудал болох "Чингис хаан" ОУНБ –д транзит урсгал авах боломж байхгүй байна. Транзит үйлчилгээний төв болгох судалгаа хийгдсэн.	Бага хэмжээний транзит урсгал хүлээн авч, нэвтрүүлэх хүчин чадлыг "Чингис хаан" ОУНБ–д бий болгоно.	-	НБУГ ЧХОУНБ
<b>ҮХЦБ-5.3.1.4 , ЗГҮАХХАХТ- 84.1</b> 4.3. Олон улсын нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлнэ.	<b>4.3.1. Олон Улсын нислэгийн чиглэл, давтамжийг нэмэгдүүлэх талаар 2014 авч хэрэгжүүлсэн ажлыг бататгах, нээсэн шинэ чиглэлүүдийг тогтворжуулах арга хэмжээ авна.</b>	I-XII сард	УБ-Парис-УБ-ын чиглэлд "Хүннү эйр" ХХК 2014.06.09-нөөс; УБ-Франкфурт-УБ-ын чиглэлд "МИАТ" ТӨХК 2014.06.19-нөөс;	Нислэг үйлдэгдэж буй олон улсын чиглэлүүдийн үр өгөөжийг дээшлүүлэх судалгаа хийж, агаарын тээвэрлэгчдэд зөвлөмж хүргүүлсэн байна.		АТЭЗЗГХАГ

			УБ-Сингапур-УБ-ын чиглэлд “МИАТ” ТӨХК 2014.09.24-ний өдрөөс эхлэн тус тус нислэг үйлдэж эхэлсэн.		
	4.2.2. Бүс нутгийн хэмжээнд агаарын тээвэрлэлтийг идэвхжүүлэх судалгааг хийнэ.	III-XII сард	-	“Чингис хаан” ОУНБ дахь транзит боломжийг ашиглан бүс нутгийн агаарын тээвэрлэлтээс олон улсын үндсэн чиглэлүүдийг тэтгэх судалгааг хийсэн байна.	АТЭЗЗГХАГ
ТИНСББ-3.14 4.4.Төрөөс алсагдсан бүс нутагт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	<b>4.4.1.Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийн төслийг боловсруулан, Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн батлуулна.</b>	I-III улирал	Хөтөлбөрийн төслийг боловсруулж байна.	Алслагдсан бүс нутагт агаарын тээврийн үйлчилгээг хүргэх төрийн бодлого тодорхойлогдож, баталгаажсан байна.	АТЭЗЗГХАГ
<b>ТИНСББ-9.1</b> 4.5.Агаарын тээврийн салбарт татварын таатай орчин бүрдүүлэх замаар агаарын тээврийн өрсөлдөх болон санхүүгийн чадавхийг сайжруулах, иргэний нисэхийн үйлчилгээний өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн санхүүгийн бодлогыг төрөөс баримтална.	<b>4.5.1. Олон улсын нисэх буудал, агаарын навигацийн үйлчилгээний зориулалттай техник, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх чиглэлээр судалгаа хийж санал боловсруулна.</b>	II-IV улирал	Эдгээр техник тоног төхөөрөмжийг гаалийн импортын татвараас чөлөөлөх хуулийн заалт байхгүй. Харин Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12.1.2, 12.1.5 заалтад хамруулж НӨАТ–аас чөлөөлж болох талтай.	Тооцоо, судалгаа хийж, санал боловсруулсан байна. ЗТЯ–нд бэлтгэсэн материалаа хүргүүлнэ.	АТЭЗЗГХАГ
<b>“5.0. Дэлхийн жишигт нийцсэн, аюулгүй ажиллагааг хангасан агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>					
<b>ТИНСББХАХТ-5.1</b> 5.1. Иргэний нисэхийн байгууллага нь иргэний зориулалтаар ашиглах агаарын зайн зохион байгуулалтад өөрчлөлт	<b>5.1.1. Иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын зайг ангилах, тогтоох, өөрчлөх, шинээр агаарын хаалга нээх, агаарын замуудыг тогтоох давуу эрхтэй байх талаар саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.</b>	I-XII сард	Судалгааны шатанд	Холбогдолтой эрх зүйн баримт бичгүүдэд судалгаа хийх, оролцогч талуудын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж, баримт бичгүүдэд тусгасан байна.	НХУГ

оруулах асуудлаар төрийн бусад байгууллагаас давуу эрхтэй байна.					
<u>ТИННСББХАХТ-2.1.4</u> 5.2. Ерөнхий зориулалтын агаарын хөлгүүдийн нислэгт нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэх агаарын зайг тодорхой болгож, нислэгийн холбогдох дүрэм, журмыг боловсруулна.	5.2.1. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөрийг батлуулж хөтөлбөрийн дагуу 2015 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжүүлж эхэлнэ.	I-XII сард	Хөтөлбөрийн төсөл боловсруулагдсан	Ажлын төлөвлөгөө боловсруулж, 2015 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хэрэгжүүлж эхлүүлсэн байна.	НХУГ
<u>ТИННСББХАХТ-1.2.3</u> 5.3. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын зөвлөмжийн дагуу иргэний нисэхийн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шаардлагыг хангахуйц бүтцийн шинэчлэл хийнэ.	5.3.1. Иргэний нисэхийн салбарын бүтцийн шинэчлэлтийн бодлогын хүрээнд "Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтцийг боловсронгуй болгох" арга хэмжээний хөтөлбөрийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	I-XII сард	Судалгааны шатанд	Хөтөлбөрийн дагуу 2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хүргүүлсэн байна.	НХУГ
<u>ТИННСББХАХТ-1.2.8</u> 5.4. Агаарын навигацийн үйлчилгээг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын бодлого, чиг хандлагад нийцүүлнэ.	5.4.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас стратегийн зорилт болгон дэвшүүлсэн "Global Air Navigation Plan", "Aviation System Block Upgrade" зэрэг ажлуудыг багтаасан Агаарын навигацийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг авна. Дунд хугацааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах ажлыг гүйцэтгэнэ.	I-XII сард	Судалгааны шатанд	Ази номхон далайн болон хөрш орнуудын зүгээс дээрх чиглэлд гаргасан төлөвлөгөөг судлан өөрийн орны агаарын навигацийн үйлчилгээнд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл хөтөлбөрийг агуулсан төлөвлөгөөг боловсруулсан байна.	НХУГ
	<b>5.4.2. Монгол Улсын агаарын зайд Үзүүлэлтэд тулгуурласан навигацийн хэрэгжилтийн эхний шатыг хэрэгжүүлнэ. ИКАО-гийн Ази Номхон далайн бүсийн төвтэй зурсан санамж бичгийн дагуу боловсруулагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.</b>	I-XII сард	Судалгааны шатанд	Монгол Улсын агаарын зайд Үзүүлэлтэд тулгуурласан навигацийн хэрэгжилтийн эхний шат буюу дээд агаарын зайн агаарын замууд RNAV5, RNAV10 тодорхойлолттой болсон байна.	НХУГ



				Судалгаагаар сонгосон 3-н аэродромд PBN нислэгийн журмууд боловсруулагдсан байна.		
	<b>5.4.3. Монгол Улсын агаарын зайд багагасан босоо зайчлалын футын систем /RVSM feet FLOS/-ийг хэрэгжүүлнэ.</b>	I-XII сард	Судалгааны шатанд	Монгол Улсын агаарын зайд багагасан босоо зайчлалын футын систем /RVSM feet FLOS/-ийг хэрэгжүүлсэн байна.		НХУГ
	5.4.4. Монгол Улсын агаарын хөдөлгөөний менежментийн нөөц төлөвлөгөөг боловсруулж батлуулна.	I-XII сард	Судалгааны ажил хийгдэж анхны төсөл боловсруулагдсан болно.	Монгол Улсын агаарын хөдөлгөөний менежментийн нөөц төлөвлөгөөг боловсруулж холбогдох яамаар батлуулсан байна.		НХУГ
	5.4.5. Монгол Улсын Засгийн газар болон ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын "Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийн 2016 оны хамтарсан дасгал сургуулилтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангана.	I-XII сард	-	2016 оны олон улсын хамтарсан дасгал сургуулалтад бэлтгэх		НХУГ
	5.4.6. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын "Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр" болон уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хэлэлцээрийг байгуулна.	I-XII сард	Хөтөлбөрийн төсөл боловсруулагдсан	БНХАУ-ын тал руу ажлын хэлэлцээрийн төслийг явуулж хэлэлцээрийг хоёр тал байгуулсан байна.		НХУГ
	5.4.7. Монгол Улсын Засгийн газар, БНКаЗУ-ын Засгийн газар хоорондын "Нисэхийн эрэн хайх, авран туслах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг боловсруулан Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	I-XII сард	Судалгааны шатанд	Төслийг боловсруулж Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.		НХУГ
<u>ТИННСББХАХТ-3.10</u> 5.5. Монгол Улсын агаарын орон зайн аюулгүй байдал,	5.5.1. "Иргэний нисэх, улсын нисэх хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийг боловсруулж, батална.	I-XII сард	-	"Иргэний нисэх, улсын нисэх хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөр"-ийг		НХУГ

иргэний агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангахад иргэний нисэх ба батлан хамгаалах салбар хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөртэй байна.				боловсруулах ажлыг гүйцэтгэх, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.		
<b>ТИННСББХАХТ-5.2.1</b> 5.6. Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж байгаа нислэгийн хөдөлгөөнд агаарын навигацийн цогц үйлчилгээг үзүүлнэ.	5.6.1. Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй өнгөрөлтийн болон нисэх буудлуудад хөөрч, бууж буй агаарын хөлөгт агаарын навигацийн болон агаарын хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ.	I-XII сард	-	Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй өнгөрөлтийн болон нисэх буудлуудад хөөрч бууж буй агаарын хөлөгт агаарын навигацийн болон агаарын хөдөлгөөний үйлчилгээ үзүүлнэ.		НХУГ
	<b>5.6.2. Агаарын хөдөлгөөний удирдлагын тууш зайчлалыг багасгана.</b>	III-IV сард	Судалгааг гүйцэтгэж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулсан.	Агаарын хөлөг хоорондын хэвтээ зайчлалыг багасгаж нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний технологи үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ.		НХУГ
5.7. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Холбоо, навигаци, ажиглалт ба Нислэгийн хөдөлгөөний менежмент (CNS/ATM) концепци, үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN) концепцийг 2020 он хүртэл тус тус бүрэн хэрэгжүүлж нислэгийн аюулгүй байдлыг сайжруулна.	<b>5.7.1. Агаарын навигацийн үйлчилгээг хөгжүүлэх, ICAO-гийн CNS/ATM концепци, дэд хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж, үндэсний болон бүс нутгийн дамжин өнгөрүүлэх аюулгүй, чанартай үйлчилгээг бий болгоход чиглэгдсэн мастер төлөвлөгөөг (2014-2017, 2017-2020 он хүртэлх хоёр үе шаттайгаар) боловсруулж, батална.</b>	I-XII сард	-	2014-2017 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулсан ба 2017-2020 оны урт хугацааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.		НХУГ
	5.7.2. Агаарын навигацийн тоног төхөөрөмжийн хангалт, шинэчлэлт хийж, автоматжуулалт нэвтрүүлэх замаар навигацийн үйлчилгээг өргөжүүлнэ.	I-XII сард	-	ADS-B системийг агаарын навигацийн үйлчилгээнд ашиглаж эхэлнэ.		НХУГ
5.8. Иргэний нисэхийн үйлчилгээнд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн аюулгүй ажиллагааны шаардлагыг	<b>5.8.1. Иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл хэрэгжүүлэх "Техник, технологийн шинэчлэлтийн төлөвлөгөө-г боловсруулж, батална.</b>	I-XII сард	-	Иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл "Техник, технологийн шинэчлэлтийн төлөвлөгөө-г боловсруулж,		НХУГ

бүрэн хангасан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийн шинэчлэлтийг тогтмол хийнэ.				батална.		
5.9. Нислэгийн журам зохиолт, чанар баталгаажуулалтын болон шалгалтын нислэгийн үйлчилгээ үзүүлнэ.	5.9.1. Хэнтий Өмнөговь Өвөрхангай Сүхбаатар аймгуудын нисэх буудлын хэрэглэлээр ойртолт үйлдэх нислэгийн журам зохионо.	I-XII сард	-	Нислэгийн журмуудыг гэрчилгээжүүлэн үйл ажиллагаанд ашиглах боломжтой болсон байна.		НХУГ
	5.9.2. Дорнод, Өмнөговь, Ховд, Хөвсгөл, Увс аймгуудын нисэх буудлын нисэн гарах нислэгийн журам зохионо.	I-XII сард	-	Нислэгийн журмуудыг гэрчилгээжүүлэн үйл ажиллагаанд ашиглах боломжтой болсон байна.		НХУГ
	5.9.3. Баян-Өлгий аймгийн нисэх буудлын PBN нислэгийн журмуудын зохиолтыг боловсруулна.	I-XII сард	-	Нислэгийн журмуудыг гэрчилгээжүүлэн үйл ажиллагаанд ашиглах боломжтой болсон байна.		НХУГ
	5.9.4. Шалгалтын нислэгийн төлөвлөгөөний дагуу тоног төхөөрөмжүүд болон хэрэглэлийн нислэгийн журмыг баталгаажуулан шалгаж дүгнэлт гаргана	I-XII сард	-	Шалгалтын нислэгээр 32 тоног төхөөрөмж, 10 хэрэглэлийн нислэгийн журмыг баталгаажуулсан байна.		НХУГ
<b>“6.0.Хэрэгчлэгчдийн эрэлт хэрэгцээг хангасан хялбаршуулсан, чанартай нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>						
<b>ЗГҮАХХАХТ-116.2</b> 6.1 Алтай, Донойн нисэх буудлын ашиглалтыг сайжруулах	6.1.1.Говь-алтай аймаг дахь нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг үргэлжлүүлнэ.	I-XII сард	-	Хөрөнгийн эх үүсвэрийг батлуулж барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.		СЭЗГ НБУГ
	6.1.2. Доной нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг үргэлжүүлнэ.	I-XII сард	-		-	СЭЗГ НБУГ
<b>ТИНСББХАТ-172.7.30</b> 6.2 Даланзадгад нисэх буудлыг олон улсын 4D ангиллын нисэх буудал болгох техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг төслийг боловсруулна.	6.2.1. Даланзадгад нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгох ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, ажлын зураг боловсруулах даалгаврыг боловсруулж, батлуулна.	III-IV улирал	Одоогийн байдлаар 3С /Фоккер-50/ агаарын хөлөг хүлээн авах боломжтой цагт 50 зорчигч хүлээн авах хүчин чадалтай.	ИКАО-ын 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах голчын гэрэлтүүлэгтэй, хоёр талын оролттой цемент бетон хучилттай аэродром бүхий цагт 500 зорчигчдод үйлчлэх хүчин чадалтай болно.		НБУГ
<b>ТИНСББХАТ-172.7.31</b> 6.3. Улаанбаатар хотын	6.3.1. "Чингис хаан" олон улсын нисэх буудлыг цаашид ашиглах талаар санал	III-IV улирал	"Чингис хаан" олон улсын нисэх буудлын	Төлөвлөгөөг баталсан байна.		НБУГ ЧХОУНБ

шинэ нисэх буудал ашиглалтад орохтой холбогдуулан "Чингис хаан олон улсын нисэх буудлыг ашиглах төлөвлөгөө"-г боловсруулж, хэрэгжүүлнэ.	боловсруулан ЗТЯ-нд хүргүүлж гарсан шийдвэрийн дагуу ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.		цаашид ямар зориулалтаар ашиглах нь одоогоор тодорхойгүй байна.			
<b>"7.0. Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>						
<b>ТИНСББ- 8.1.1, 8.1.2</b> 7.1.Хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгоно.	<b>7.1.1. "Иргэний нисэхийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг боловсруулж, батлуулна.</b>	I-XII сард	Судалгааны ажил хийгдэж байна.	Иргэний нисэхийн салбарын ажилтнуудыг бэлтгэх, сонгон шалгаруулах, мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэгдэнэ.		ЗХНТГ /Ажлын хэсэг/
	7.1.2. ИНЕГ, түүний харьяа байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах, чадавхийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан, батлуулж, хэрэгжүүлнэ.	I-XII сард	Хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан байна.	Ажилтнуудыг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох сургалтад хамруулсан байна.		ЗХНТГ
	7.1.3. Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад ИНЕГ-ын зардлаар окутнуудыг үргэлжлүүлэн суралцуулна.	I-XII сард	-	Иргэний нисэхийн салбарт хэрэгцээ шаардлагатай мэргэжлээр ажилтнуудыг бэлтгэнэ.		ЗХНТГ
<b>ТИНСББ- 8.1.3</b> 7.2. Иргэний нисэхийн салбарын ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тэдний гүйцэтгэж байгаа ажил үүрэг, ур чадварт нийцсэн цалин хөлс, урамшууллын механизм, нийгмийн хамгааллын асуудлыг олон улсын жишигт нийцүүлэн Иргэний нисэхийн тухай хууль тогтоомжид тусгана.	<b>ТИНСББХАТ-172.10.47</b> <b>7.2.1. "Иргэний нисэхийн салбарын ажилтнуудын цалин хөлсний талаар баримтлах бодлого"-ыг боловсруулж, батална.</b>	II улиралд	"Иргэний нисэхийн салбарын ажилтнуудын цалин хөлсний талаар баримтлах бодлого"-ыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	Иргэний нисэхийн салбарын ажилтнуудын цалин хөлсний талаар баримтлах бодлогыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлыг олон улсын стандарт жишигтэй уялдуулан боловсруулсан байна.		Ажлын хэсэг

<b>"8.0. Үр ашигтай хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх " гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>						
8.1.Салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн яамны журам, зааврын дагуу хэрэгжүүлнэ.	8.1.1. Монгол Улсын 2015 оны төсвийн хөрөнгө оруулалтаар болон ИНЕГ-ын өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	I-XII сард	-	Төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.		СЭЗГ
	8.1.2.ИНЕГ-ын 2015 оны бараа ажил, үйлчилгээ худалдан авалтын биелэлтийн ерөнхий тайлан, мэдээг Зам, тээврийн яам болон Сангийн яаманд тогтоосон хугацаанд хүргүүлж, холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байрлуулна.	I-XII сард	-	Мэдээлэл нийтийн хүртээл болсон байна.		СЭЗГ
	8.1.3. ТЕЗ-ийн 2016 оны төсвийн багцад тусгагдах улсын төсөв, Иргэний нисэхийн ерөнхий газрын өөрийн хөрөнгөөр худалдан авах бараа ажил үйлчилгээний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 2016 оны төслийг боловсруулж, Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	I-XII сард	-	Төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, ЗТЯ-нд хүргүүлсэн байна.		СЭЗГ
<b>"9.0. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ</b>						
9.1. Гадаад харилцааг өргөжүүлнэ.	9.1.1.Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO) болон (ICAO) –ын дэмжлэгтэйгээр бүс нутагт хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагааны хөтөлбөрүүдэд (COSCAP-NA, CASP-AP, FPP, TRAIN AIR PLUS, CAPSCA) идэвхитэй оролцоно.	I-XII сард	-	CASP-AP аудит үзлэг 2015 оны IV улиралд Монгол Улсад хийгдэхтэй холбогдуулан гадаад хамтын ажиллагааны чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллах, хамтын ажиллагааны бусад хөтөлбөрүүдэд оролцож өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна		АТЭЗЗГХАГ
	9.1.2.(CANSO, IFATCA, IATA, DFS) зэрэг иргэний нисэхийн төрөл мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	I-XII сард	-	IATA, CANSO, IFATCA-ийн үйл ажиллагаанд оролцож, бусад орны туршлагаас суралцана.		АТЭЗЗГХАГ НХУГ

	9.1.3.Гадаад улс орон болон олон улсын иргэний нисэхийн байгууллагуудтай иргэний нисэхийн чиглэлээр байгуулах 2 талын болон олон талт хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	I-XII сард	-	Гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах бэлтгэл ажлыг хангасан байна	АТЭЗЗГХАГ
	9.1.4. Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын өмнө хүлээсэн санхүүгийн үүргийг биелүүлнэ.	I-XII сард	-	Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын татварыг тогтоосон хугацаанд төлсөн байна.	СЭЗГ
<b>ХОЁР. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ</b>					
2.1.Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авна.	2.1.1. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлнэ.	I-XII сард	-	Ажилтнуудынхаа нийгмийн хамгаалал, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийг сахин хамгаалах, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй бодлогын үр дүн, үр нөлөөг үнэлж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн цаашид цэгцтэй арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж эхлүүлсэн байна.	ЗХНТГ
	2.1.2.Амьдралын гачигдалтай болон орон сууцны хүнд нөхцөлд амьдардаг ажилтнуудад орон сууцтай болоход дэмжлэг тусламж үзүүлнэ.	III-IV улирал	Үйлдвэрлэлийн албадын 2015 оны төсвийн төсөлд тусгагдсан.	Батлагдсан төсвийн хэмжээнд ажилтнуудыг орон сууцны хөнгөлөлтөд хамруулсан байна.	ЗХНТГ
2.2 ИНЕГ, харьяа байгууллагад хууль тогтоомж, төр, засгийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.	2.2.1. ИНЕГ-аас боловсруулан гаргаж байгаа баримт бичгийн төсөл хууль тогтоомжид хэрхэн нийцэж байгааг хянаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	I-XII сард	-	Батлагдан гарч байгаа баримт бичиг хууль тогтоомжид нийцсэн байна.	ХЭЗДБГ
	2.2.2. Дээд газрын болон Зам, тээврийн сайд, ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнана.	I-XII сард	-	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг 90%-д хүргэнэ.	ЗХНТГ

2.4. Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитыг хэрэгжүүлнэ.	2.4.1 Дотоод аудитын үйл ажиллагаанд шаардлагатай эрх зүйн акт, журмыг шинэчлэн боловсруулж, батлуулан, хэрэгжүүлж ажиллана.	I-XII сард	2014 онд хийгдсэн дотоод аудитын дүгнэлт, судалгаатай.	Дотоод аудитын эрх зүйн орчин боловсронгуй болж үйл ажиллагаа сайжирна.	НААХЗДХА
	2.4.2. Их, дунд эрсдэлтэй үйл ажиллагаанд дотоод аудит хийх хуваарийг боловсруулан, батлуулж, түүний дагуу аудит хийнэ.	I-XII сард	СЯ, ЗТЯ-ны ХШҮДАГ-тай хамтран “Чингис хаан” ОУНБ-д эрсдлийн аудит хийсэн.	Шалгалтын хуваарийг батлуулан, түүний дагуу шалгалтыг бүрэн хийж, үр дүнг удирдлагад танилцуулж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлсэн байна.	НААХЗДХА
	2.4.3. Хийгдсэн иж бүрэн дотоод аудитын зөвлөмж, актын биелэлтийг заасан хугацаанд гүйцэтгэлийн тайлангаар авч, хэрэгжилтэд хяналт тавина.	I-XII сард	-	Зөвлөмж, актын хэрэгжилтийг 80%-аас доошгүй хувьд хүрсэн байна.	НААХЗДХА
2.5. Хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, тус ерөнхий газрын чиг үүрэгтэй холбогдон гарсан шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, үр дүнг тайлагнана.	2.5.1. Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ, бусад бодлогын баримт бичиг, Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, хууль, тогтоомж, дээд газрын тогтоол шийдвэр, Салбарын сайдын зөвлөлийн хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын, хэрэгжилтэд хагас жил болон жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, ИНЕГ-ын даргад танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулж, хэрэгжилтэд хяналт тавина.	VI, XII сард	-	Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээллээр удирдлагыг хангаж, хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.	ЗХНТГ НААХЗДХА

2.6. Бусад ажил	2.6.1. Монгол Улсад нисэх хүчин үүсч хөгжсөний 90 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх төсөв батлуулах, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу арга хэмжээг зохион байгуулна.	II-VI сард	Ажлын хэсэг томилогдон, төлөвлөгөө батлуулан ажиллаж байна.	Ойн баярын арга хэмжээг батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.		ЗХНТГ /Ажлын хэсэг/	
	2.6.2. Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох дээд газарт тайлагнана.	IX-XI сард	-		Өвөлжилтийн бэлтгэлийг 100% хангасан байна.		ЗХНТГ Газрууд
	2.6.3. Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд барагдуулна.	I-XII сард	-		Хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна.		ЗХНТГ
2.7.Төсвийн тухай хуулийг мөрдөнө.	2.7.1.Улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлнэ.	I-XII сард	Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хууль батлагдсан	88.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.		СЭЗГ	
	2.7.2. Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны төсвийн төсөл, 2016-2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийг нэгтгэн боловсруулан Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	IV сард		Судалгаа хийж байна.	Төсөв, төсөөллийг боловсруулан, холбогдох дээд байгууллагад хүргүүлсэн байна.		СЭЗГ
	2.7.3.Санхүүгийн хагас жил, жилийн тайлан, балансыг хугацаанд гаргаж, холбогдох дээд байгууллагад хүргүүлж, холбогдох мэдээллийг Шилэн дансны тухай хууль, журмын дагуу байгууллагын Вэб сайтад байрлуулна.	I-XII сард	-		Тогтоосон хугацаанд гүйцэтгэж, хэрэглэгч онлайн мэдээлэл авах нөхцөл бүрдсэн байна.		СЭЗГ
	2.7.4. Өр, авлагыг хугацаанд нь барагдуулах арга хэмжээ авна.	I-XII сард			Гадаадын авиакомпаниудын авлага 90 хувь төлөгдсөн байна.		СЭЗГ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ ..... /Ц.ЭРДЭНЭБИЛЭГ/

ХЯНАСАН:

ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХШУДАГ-ЫН ДАРГА ..... /Б.БЯМБАЖАВ/

ЗАМ ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХШУДАГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ..... /А.ТОГОСБОЛД/